

## ҮНДЭСНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

**Энэхүү танилцуулга Нэгдсэн Вант Улсын хэмжээнд Үндэсний Эрүүл Мэндийн Үйлчилгээ (ҮЭМҮ) хэрхэн явагддагийг тайлбарлана.**

Үндэсний Эрүүл Мэндийн Үйлчилгээ нь Нэгдсэн Вант Улсын хэмжээнд эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх бөгөөд улсын татвараас санхүүждэг. Орогнол хүсэгчдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг хүлээн авзевшөөрсөн тохиолдолд тэрээр эрүүл мэндийн үйлчилгээнд үнэ төлбөргүйгээр хамрагдаж болно. Та Орогнол Хүсэгчдийг Дэмжих Үндэсний Төв (ОХДҮТ)-өөс олгосон, эсвэл эмийн сангуудад байдаг **HC2** маягтыг бөглөснөөр үнэ төлбөргүйгээр эм авах, шүдээ эмчлүүлэх, нүдээ үзүүлж хараагаа шалгуулах болон зарим тохиолдолд шил хийлгэх үйлчилгээг авч болно.

ҮЭМҮ-ний салбарт ажилладаг эмч, сувилагч, орчуулагч хэн боловч Таны тухай мэдээллийг таны зөвшөөрөлгүйгээр өөр хүмүүс болон албан байгууллагуудад өгөхгүй. Эмнэлгийн үйлчилгээний нууц хадгалагдах бөгөөд энэ нь орогнол хүссэн таны өргөдлийг хянан үзэхэд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

### **Би эрүүл мэнддээ тусламж хэрхэн авах вэ?**

Хэрвээ Та болон таны гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн өвчтэй юм уу, эсвэл эрүүл мэнддээ санаа зовниж байгаа бол та өөрийн амьдарч буй тойргийн Ерөнхий Эмчлэгч Эмч (ЕЭЭ)-д үзүүлэх хэрэгтэй. ЕЭЭ-ийн ажлын газрыг Эрүүл Мэндийн Төв (ЭМТ) гэж нэрлэдэг.

Та хэрэгтэй үедээ эмнэлгийн тусламжийг авахийн тулд эрүүл мэндийн төвдөө аль болох хурдан бүртгүүлэх шаардлагатай. Бүртгүүлэхийн тулд өөрийн нэр, төрсөн он сар өдөр, оршин суугаа хаяг болон хэрвээ байгаа бол утсаа өгөх ёстой. Танд байр олж өгч тусалсан ажилтан хэрхэн бүртгүүлэх журмыг мэдэж байгаа.

Зарим ЕЭЭ нар бүх үйлчлүүлэгчдээсээ эрүүл мэндээ шалгуулсан байхыг шаарддаг бөгөөд үүнийг ихэвчлэн сувилагч нар хийдэг. Та эрүүл байсан ч ийнхүү эрүүл мэндээ шалгуулах нь маш чухал шүү.

ЕЭЭ Таныг бүртгэж авахгүй байвал Та орон нутгийн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэгч итгэмжлэгдсэн хүнээс тусалцаа авч эмчтэй уулзаж болно.

### **Эмчид хэрхэн бүртгүүлэх вэ?**

Орон нутгийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчтай уулзахын тулд та биеэр очиж буюу утсаар холбогдож үзүүлэх цагаа урьдчилан товлох ёстой. Хэдийгээр заримдаа боломжгүй байдаг ч Та эрэгтэй, эмэгтэй эмч, сувилагчийн алинд нь үзүүлэхээ сонгож бас болно.

Онц яараагүй бол Та үзүүлэх цагаа хэдэн өдрөөр хүлээж магадгүй. Хэрвээ яаралтай үзүүлэх шаардлагатай бол хүлээн авагчид үзүүлэх

цагаа товлохдоо энэ тухайгаа хэлээд тухайн өдөртөө үзүүлж болно. Та эрүүл мэндийн төвд ирж чадахааргүй бол эмч юм уу сувилагч гэрээр тань очиж үзлэг хийж болно.

Эмчтэй уулзах хугацаа хүн тус бүрт 5-10 минут үргэлжлэх тул Та гэр бүлийн гишүүддээ тус бүрт нь цаг авах хэрэгтэй.

Товлосон цагтаа хожимдолгүй ирэх буюу хэрвээ ирж чадахааргүй бол урьдчилан мэдэгдэж үзлэгийн цагаа хүчингүй болгох хэрэгтэйг анхаараарай .

### **Би Англиар ярьж чадахгүй бол...**

Хэрвээ Танд орчуулагч шаардлагатай бол үзлэгийн цаг товлохдоо энэ тухайгаа хүлээн авагчид мэдэгдэж, ямар хэлээр ярьдагаа хэлээрэй. Тэд танд орчуулагч захиалах буюу утсаар орчуулга хийх хүнийг олно. Эмч Та хоёр хоорондоо хэлээ ололцож, ойлголцох нь Эмч таныг үзээд үнэн зөв оношлоход маш чухал болно.

### **ЕЭЭ-тэй өөр хэн хэн ажилладаг вэ?**

- Сувилагч нар Англид маш сайн бэлтгэгдэж сургагдсан хүмүүс байдаг. Тэд нар вакцинжуулах тариа тарих, урьдчилан сэргийлэх үзлэг хийх болон чихрийн шижин мэтийн зарим хуучин архаг өвчнүүдэд эмчилгээ хийж чадахаас гадна эрүүл мэндийн ерөнхий зөвлөгөөг өгч болно.
- Жирэмсэн эмэгтэйчүүдийн туслагч нар төрөх гэж байгаа буюу сая төрсөн эмэгтэйчүүдийг халамжлан хүүхдээ асрахад нь тусалдаг. Төрөхийн өмнөх асаргаар “ante-natal” гэх ба төрсний дараах асаргаар “post-natal” гэж нэрлэнэ.
- Эрүүл мэндийн үйлчлэгч нар ялангуяа хүүхдүүдийг тэдний гэр бүлийнхнийг эрүүл байлгахад голлон анхаарах бөгөөд танай гэрт зочлон ирж үйлчилгээ үзүүлнэ.

### **Хэрвээ надад тусгай (нарийн мэргэжлийн) эмч хэрэгтэй бол яах вэ?**

Таны ЕЭЭ ерөнхийдөө таны эрүүл мэндэд анхааран үзлэг эмчилгээг хариуцах бөгөөд нарийн мэргэжлийн эмч буюу зөвлөх шаардлагатай болох, эсвэл эмнэлэгт хэвтэх эсэхийг шийдвэрлэнэ. Англид эдгээр нарийн мэргэжлийн эмч нартай уулзахад хүн бүр хүлээх хэрэгтэй болно.

Эмнэлэг Таныг эмчтэй уулзах бүх зүйлийг хариуцна. Үзүүлэхдээ орчуулагч шаардлагатай бол та эмнэлэгтэй урьдчилан холбоо барих ёстой.

Энэхүү эмнэлгийн үзлэгийг зарим үед таны гэрээс зайтай газар товлож магадгүй боловч, Та HC2 маягттай бол нийтийн тээврийн зардлаа олж болох талтай.

### **Өвчтөний Эрүүл мэндийн Дэвтэр**

Хэрвээ танд Өвчтөний Эрүүл мэндийн Дэвтэр (цэнхэр дэвтэр) олгосон бол энэ дэвтрээ эмч, сувилагчид очих болгондоо биедээ авч явах ёстой.

Энэ дэвтэрт байгаа мэдээлэл зөвхөн Танд болон Эрүүл Мэндийн Төвийн ажилтнуудад л зориулагдсан бөгөөд өөр хэн ч үзэх эрхгүй.

## **Өөр хэн надад туслах вэ?**

### Эм тариа

Хэрвээ таны эмч Таныг эм уух шаардлагатай гэж үзвэл жор бичиж өгнө. Уг жорыг аваад эмийн санд очих хэрэгтэй. Та СН2 маягттай бол жорыг үнэгүй авах боломжтой. Эмийн санч танд ойр зуурын эмчилгээний талаар зөвлөгөө өгч чадна. Зарим нэг өвчин намдаагч буюу ханиадны эмийг эмийн сангаас жоргүйгээр авч бас болно.

### Шүдний эмнэлэг

Хэрвээ Таны шүд өвдвөл шүдний эмчид очих шаардлагатай болно. Ингэхийн тулд шүдний эмчид үзүүлэхээр бүртгүүлж, дугаар авна. Дугаар авч чадахгүй буюу хүндрэлтэй байгаа бол ЭМТ рүү шууд холбогдож, эсвэл орон нутгийн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэгч итгэмжлэгдсэн хүнээс тусалцаа авч уг дугаарыг авч болно.

### Нүдний эмч

Хэрвээ Та нүдний хараагаа шалгуулах буюу шинээр шил хийлгэх шаардлагатай бол нүдний эмчид үзүүлэх дугаар авах хэрэгтэй. Хотын ихэнх дүүрэгт эмч болон шилний дэлгүүр, тасаг байгаа. СН2 маягтаар нүдээ үнэгүй үзүүлэх буюу зарим төрлийн шилийг үнэгүй авч болно. Үүнийг эмчээсээ асуугаарай.

## **Танай Эрүүл Мэндийн Төв хаалттай байвал...**

ЕЭЭ-ийн ажилладаг ЭМТүүд ихэвчлэн Даваа- Баасан гарагуудын 08:30 цагаас 18:30 цаг хүртэл ажилладаг. Бусад цагт (шөнийн болон амралт баяр ёслолын үеэр) Танд эмнэлгийн зайлшгүй тусалцаа шаардлагатай бол ЭМТ-ийг онгойхыг хүлээлгүйгээр түүнийг авч болох юм.

Ингэхийн тулд орон нутгийн (дүүргийн) ажлын бус цагийн үйлчилгээний газар луу буюу доорхи утсаар холбогдож шаардлагатай зөвлөгөө мэдээллийг авах хэрэгтэй. Мөн танд ЕЭЭ-д очихыг зөвлөхөөс гадна гэрээр дуудлагын эмчийг тан руу явуулж болно.

Мөн ЭМТ хаалттай үед Үндэсний Эрүүл Мэндийн Үйлчилгээний Төв рүү 0845 46 47 утсаар холбогдож зөвлөгөө авч болох бөгөөд гэрийн буюу нийтийн телефон утсаар холбогдож ярих нь гат утаснаасаа холбогдож ярьснаас хавьгүй хямдхан байх болно.

Хэрвээ танай эмч англиар ярьдаггүй бол ЭМТ болон орон нутгийн ажлын бус цагийн үйлчилгээний газраас танд орчуулагч өгч тусалж болно. Та өөртөө аль хэлээр орчуулагч авахыг хүсч байгаагаа хэлэхэд л

хангалттай. Хэрвээ Та англиар огт ярьж чадахгүй бол найз нөхөд, хамаатан саднаасаа юм уу, танд туслагч ажилтнаасаа тусламж хүсч орчуулагч ирэхийг хүлээх хэрэгтэй. Сайн орчуулагчтай болсны дараа л өөрийнхөө өвчин, эрүүл мэндийн асуудлаа эмчид танилцуулах хэрэгтэй шүү. Танаас оршин суугаа газрын хаяг болон бусад мэдээллийг авч болох ч энэ мэдээллийг өөр хэнд ч өгөхгүй, нууц хэвээрээ үлдэнэ.

ҮЭМТөвөөс эрүүл мэндийн зөвлөгөө хүсвэл: 0845 46 47 - руу залга  
ЭМТ хаалттай үед орон нутгийн ажлын бус цагийн үйлчилгээний газраас эмнэлгийн зөвлөгөө хүсвэл: .....залга

### **Түргэн тусламж шаардлагатай бол яах ва?**

Та болон танай гэр бүлийнхнээс хэн нэгэн хүн хүндээр өвчлөн, ЭМТ онгойхыг хүлээж чадахааргүй, яаралтай тусламж хэрэгтэй бол 999 рүү залгаж (энэ нь үнэгүй), эсвэл орон нутгийн эмнэлгийн Ослын болон Яаралтай Тусламжийн Хэлтсээс түргэн тусламж дуудаж болно. Гэхдээ энэ тусламжийг зөвхөн онцгой тохиолдолд л аваарай. Ойр зуурын өвчин болон бусад ялихгүй шалтгаанаар Ослын болон Яаралтай Тусламжийн Хэлтсээс тусламж авахгүй байхыг зөвлөж байна.

ЕЭЭ болон орогнол хүсэгчдэд туслах орон нутгийн эрүүл мэндийн багтай холбогдох:

### **ABOUT THE NHS MONGOLIAN OCTOBER 2005**

**HEALTH & HOUSING RESOURCES. UNIT 39 CONCOURSE HOUSE  
DEWSBURY ROAD LEEDS LS11 7DF  
T. 0113 2770999 F. 0113 2704753  
email <[1kelvin@healthandhousing.org](mailto:1kelvin@healthandhousing.org)>**